

“ПЕРЕСТРОЙКА”-ГИЙН ҮЗЭЛ САНАА МОНГОЛЫН АРДЧИЛСАН ХУВЬСГАЛД НӨЛӨӨЛСӨН НЬ

Д. Наранцэцэг Доктор (МУБИС)
М.Шолпан Докторант (ХААИС)

Түлхүүр үг. “Перестройка”, социалист систем, “гласность”, “хүйтэн дайн”, эдийн засгийн зогсонги байдал, шинэтгэл

Оршил

Бидний хойд хөрш хуучны Зөвлөлт Холбоот Улс \ЗХУ\ өнөөгийн Оросын Холбооны Улс \ОХУ\ нь манай орны хөгжил дэвшилд ихээхэн үүрэг гүйцэтгэж ирсэн бөгөөд хоёр улсын харилцааны тийхэнд ээдрээтэй асуудлууд байдаг ч гэрэл гэгээтэй, ямагт дурсагдах, үнэлж баршгүй зүйл ч олон бий гэдэгт та бүхэн санал нэгдэх болов уу? Өнөөдрийн толилуулан буй асуудал нь “Перестройка”-гийн үзэл санаа Монголын ардчилсан хувьсгалд хэрхэн нөлөөлсөн тухай хөндөх юм. ЗХУ-д өрнөсөн “Перестройка” нь дотоод хил хязгаараасаа халин гарч, ЗХУ-ын нелеений бисэд хамрагдаж ирсэн социалист орнуудад бүхэлд нь нөлөөлснөөр хэний ч таамаглаж байгаагүй үр дүнд хүргэсний нэгэн тод жишээ нь 1990 оны Монголын ардчилсан хувьсгал юм.

М.С.Горбачёв “Перестройка”-г яагаад эхлүүлэх болов? Тэрээр хэрхэн яаж нам төрийн удирдлагад түргэн гарч ирэв? “Перестройка”-г эхлүүлэх үзэл санаа хэрхэн яаж бүрэлдэв? “Перестройка” тийний санасан төлөвлөсөн зүйл болж чадав уу? гэх мэт олон асуудал судлаачдын анхаарлыг татсан хэвээр байна. Иймд ЗХУ-д өрнөсөн “Перестройка”-гийн хүрээнд шинээр боловсруулагдсан гадаад бодлого нь олон улсын нөхцөл байдалд яаж нөлөөлж, социалист орнуудын хувь заяаг хэрхэн хөтлөн дагуулсан зэрэг асуудлыг Монголын ардчилсан хувьсгалын жишээн дээр үзэж, зохих дүгнэлтийг хийхээр зорилоо.

Хэвлэлийн тойм

“Перестройка”-гийн талаар судалгаа хийсэн эрдэмтэн, нэрт хүмүүсийн ном зохиолоос дурьдвал: М.С.Горбачёв. “Өөрчлөн байгуулалт шинэ сэтгэлгээ: Манай оронд болон дэлхий дахинд”. УБ., 1988, М.С.Горбачёв. “Октябрь өөрчлөн байгуулалт: Хувьсгал үргэлжилж байна”. УБ., 1997, А.Л.Шевякин. “Разгром советской державы. От “оттепели” до “Перестройка”” М., 2004, К.Н.Брутенц. Несбывшееся. Неравнодушные заметки о перестройке. М., 2005, В.Б.Кувалдин, А.Б.Вебер. Прорыв к свободе: О перестройке 20 лет спустя /критический анализ/ М., 2005, Перестройка 20 лет спустя. М., 2005, М.С.Горбачёв. Понять перестройку... Почему это важно сейчас. М., 2006 гэх мэт. ЗХУКН-ын бүгд ба их хурлуудын материал, М.С.Горбачёвын илтгэл, өгүүлүүдийг эс тооцвол монгол хэл дээр судлагдаж, орчуулагдсан ном зохиол, материал тун ховор байна.

Судалгааны үр дүн

1. ЗХУ дахь “Перестройка”, тийний олон улсын ач холбогдол:

1980-аад оны эхэн гэхэд Зөвлөлтийн нийгэм бихэлдээ эдийн засгийн зогсонги байдалд орсон байлаа. ЗХУ-ын удирдагчид, жирийн иргэд улс орон хүнд хэцүү байдалд орсныг мэдэрцгээж, 1982 оноос эхлэн Л.И.Брежневийн араас ЗХУКН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны ерөнхий нарийн бичгийн дарга нарыг оршуулж, улс оронд сэтгэл зүйн уур амьсгал ч бас таагүй болохын зэрэгцээ нийгмийн амьдрал улам бүр уруудах шатандаа орж байв. Цорын ганц ЗХУКН-ын бүхий л үйл ажиллагааг намын хүнд суртлын аппарат хатуу хянаснаар ардчилал, эрх чөлөө хумигдаж, нийгэмд хүмүүсийн боловсролын түвшний зааг ялгаа нэмэгдэн, эдийн

засгийн механизмууд зогсонги байдалд орж Ю.Андроповыг томилогдох жилд үйлдвэрлэлийн уналтын хэмжээ дээд цэгтээ хүрч, улс орны хөгжлийн хурд саарч эхэлсэн хийгээд аж ахуйн салбар доголдож, олон асуудлууд хуримтлагдсан нь Ернэдийн орнуудын хөгжлөөс улам бүр хоцроход хүргэсэн юм.

Энэхий нөхцөл байдал нь нийгмийн амьдралын бусад салбарт нөлөөлж, “Перестройка”-г зайлшгүй, гарцаагүй хэрэгжүүлэх шаардлага урган гарсан. 1985 оны 3 дугаар сарын 11-нд А.А.Гормыко Төв Хорооны бага хурал дээр Улс Төрийн Товчооны нэрийн өмнөөс ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн даргаар М.С.Горбачёвыг сонгох саналыг оруулснаар *Горбачёвын эрин* эхэлсэн юм. Улс оронд үүссэн нөхцөл байдал өөрчлөлтийг шаардаж байсан хэдий ч аливаа шинэтгэл нь саад бэрхшээлтэй тулгарч, хүнд хэцүү явагдана гэдгийг тэрээр сайтар ойлгож байсан боловч цаашид хүлээх ямар ч боломжгүй гэдгийг хэнээс ч илүү мэдэж байв.

М.С.Горбачёвын “Перестройка”-гийн үзэл санаанд ЗХУ-ын төрийн жолоог барьж ирсэн олон хүний үзэл бодол, хэрэгжүүлж ирсэн бодлогын ололт амжилт, алдаа дутагдал, зүй ёсоор нөлөөлсөнг тэрээр өөрийн бичсэн дурдатгалдаа “Миний хувьд би Ленинд итгэдэг, өнөөдөр ч итгэсээр байгаа. Тэрээр Оросын түүхийн салшгүй нэгэн хэсэг. Ленин надад юугаараа үнэ цэнтэй байдаг вэ гэвэл, тэрээр коммунизмыг оюуны дэвшилтэй холбож, коммунизм өөрийгөө хүн төрөлхтний бтээсэн бүхий л мэдлэгээр баяжуулах шаардлагатай гэдгийг олж харсанд оршино” [5.15] хэмээн өгүүлсэн байдаг. Тэрээр улс орон хүнд, гарах гарцгүй байсан нөхцөлд засгийн эрхийг авч, дөрвөн жилийн дараа коммунизмын зарчмуудыг шууд хэрэгжүүлэх замаар явсан нь бидний алдаа байж гэдгийг ил тод хүлээж, эдийн засгийн шинэ бодлогыг гаргаж ирсэн юм. Харин Н.С.Хрущёвын тухайд “Перестройка”-гийн эхлэл болох өөрчлөх үйл явцын анхны алхмыг хийсэн хин бегеэд “сталинизмыг шүүмжилж, тоталитар төрийн хор уршгийг илрүүлж, капиталист орнуудтай энх тайвнаар зэрэгцэн орших гадаад бодлогыг нэвтрүүлж, эдийн засгийн шинэтгэлүүдийг хэрэгжүүлэх оролдлогыг хийж” чадсанд түүний иргэний гавъяа оршино. Өөрөөр хэлбэл “Н.С.Хрущёвын дэмжлэгээр өрнөсөн илчлэх үйл ажиллагаа нь ихээхэн үүрэг гүйцэтгэсэн билээ” [1.30] хэмээн дүгнэсэн байдаг. М.С.Горбачёв урьд өмнөх удирдагчдынхаа ололт амжилтыг ийнхүү дүгнэн үзсэнээр “Перестройка”-гийн үндсэн зорилго нь “тоталитар төрийг бүрдүүлсэн сталинизмыг даван туулах явдал болно” [5.16] хэмээн үзэж байв.

ЗХУ задарснаас хойш дэлхийн олон судлаачид мөн оросын түүхчид “Перестройка”-гийн талаар дүгнэн бичихдээ М.С.Горбачёвын боловсруулан гаргасан “гласность” буюу ил тод байдал, “новое политическое мышление” буюу улс төрийн шинэ сэтгэлгээ (дэлхийн үйл хэрэгт шинээр хандах арга зүй ба философи) зэрэг нь жинхэнэ утгаараа хэрэгжсэнээр ЗХУ-ын задралыг тавьсан хэмээн үзэж, харин оросууд М.С.Горбачёвыг ЗХУ-ыг задрахад хүргэсэн гол буруутан мэт дүгнэж байсан ч коммунист систем задран унах үйл явц хэдийнээ ЗХУ болон социалист системийн орнуудад бүрэлдэж, чухамхүү ЗХУ-аас энэхүү үйл явц эхэлсэн нь тэдгээр орнуудад томоохон түлхэлт болж, эр зориг, хүч чадал нэмсээр ардчилсан хувьсгалууд ар араасаа гарч социалист системийн орнууд хөгжлийн зөв замдаа шилжиж чадсан юм.

1985 оны 4 дүгээр сард болсон ЗХУКН-ын Төв Хорооны Бүгд хурлаас “Улс орон хямралын босгон дээр байна” [4.21] гэсэн дүгнэлт хийгдсэн нь оросын ард түмний хойшлуулашгүй хэрэгцээ шаардлага нь “Перестройка” болсныг дахин нотлон харуулсан хэрэг байв. Өнөөдрийн өндөрлөгөөс харахад М.С.Горбачёвын “Перестройка”-г санаачлан хэрэгжүүлсэн өргөн цар хүрээтэй өөрчлөлтүүд нь тогтож буй системийн алдаа дутагдлыг засаж сайжруулах, эдийн засгийн зогсонги байдлаас гарах, нам доторх ардчиллыг бий болгож, шүүмжлэлийг ил тод болгосон. Харин Коммунист Нам л улс орныг цаашид удирдан чиглүүлэх болно хэмээн үзсэн нь түүний

алдаа байсан юм. Үүнийгээ ч тэрээр хожим нь хүлээн зөвшөөрч дурдатгалдаа “бид тоталитар системийг халах ёстой байсан юм” хэмээн тэмдэглэсэн байдаг.

Социалист ертөнцийг удирдан чиглүүлэгч улс оронд энэхүү шинэтгэл эхэлсэн нь олон орны анхаарлыг татаж байлаа. ЗХУ-ын “Перестройка”-г, түүний өрнөлтийг ах дүү социалист орнууд, дэлхий нийтээр ажигласаар байв. Үүнтэй нэгэн зэрэг социалист орнууд ч мөн социалист системийн тогтолцоо, нэг намын дарангуйллыг зоригтой шүүмжилж, социалист орнуудын дотоод амьдрал бийхэлдээ хөдөлгөөнд орж эхэлсэн юм.

М.С.Горбачёв ЗХУ нь “Перестройка”-г хэрэгжүүлэхэд 1980-аад оны дунд үеэс өмнө бэлэн байсан юм гэж бичсэн байдаг. Иймд нийгмийн төрөл бүрийн шат, институциас ирж буй мэдээлэлд үндэслэн өөрчлөлтийг нэн даруй хэрэгжүүлэхгүй бол ЗХУ-д үнэлж баршгүй хэмжээний дэлбэрэлт явагдана гэж нэг бус удаа тэрээр анхааруулж, бид цаашид өөрсдийгөө хууран мэхлэх шаардлагагүй юм, нидээрээ харж буй зүйлдээ итгэж, амьдралын хэрэгцээг онолын дээгүүр тавихаас еер аргагүй гэж үзэж байв. Үүний тулд “Социализмыг боловсронгуй болгох” замаар шинжлэх ухаан техникийн дэвшлийг хурдасгах томъёоллыг гарган, үүгээрээ хөгжингүй орнуудаас хоцорч ирсэн нийгэм эдийн засгийн хөгжлийн хоцрогдлыг даван туулах бодлогыг эхэндээ дэвшүүлсэн юм.

Ийнхүү М.С.Горбачёв зөвлөлтийн нийгмийн шилдэг төлөөллийг (тухайлбал, Николай Иноземцев зэрэг эрдэмтдийг) шинэчлэх үйл явцад оролцохыг уриалсанаар анх удаа намын удирдлага сэхээтнүүдийнхээ дуу хоолой, шүүмжлэлийг жинхэнэ утгаар нь сонсох болжээ. “Перестройка”-г эхлүүлэхэд ЗХУ-ын хувьд хамгийн гол тулгамдсан асуудал юу байв? хэмээх асуултад тэрээр төрийн системийн хэт төвлөрөлт, хүнд суртлын аппарат, дарангуйллын арга барил зэргийг нэрлэсэн байдаг. Үүнийг эвдэх анхны алхмыг Н.С.Хрущёв хийсэн ч түүний араас ЗХУ-ыг удирдсан Л.Брежнев, Ю.Андропов, И.Косыгин нарын шинэтгэл нь хэрсэн хилээж буй ир дүнд хүргэж чадаагүй юм.

“Перестройка” нь хоосон хөрсөн дээр бий болоогүй. Түүний үндсэн чиглэлийг эхний үед хувийн хүрээнд, албан бус журмаар тунгаан хэлэлцэж, яваандаа намын удирдлагын хэмжээнд хэлэлцэх болсны жишээ нь “Новосибирскийн илтгэл” юм. 1985 онд төр, намын удирдлагад гарсан хүмүүс ЗХУ-ын эдийн засгийн гүн гүнзгий хямралын тухай, олон улсын байдал туйлдаа хүртэл хурцадсан нөхцөлд эдийн засгийн хямралтай холбоотойгоор ЗХУ-ын нэр хүнд улс орон дотроо тадийгүй олон улсын тавцан дээр унаж, түүний байр суурь суларч эхэлснийг хүлээн завшөөрсөн явдал байв.

“Перестройка”-гийн зорилт их өргөн цар хүрээг хамарсан юм. Энэ нь үйлдвэрлэлийн нөхцөл, эдийн засгийг удирдах удирдлага, олон улсын хэмжүүрээр ЗСБНХУ-д хандах хандлагыг ул үндсээр нь өөрчлөх, 30-аад оны үеэс бий болсон сталинизмын уламжлал, захиран тушаах удирдлагын хор уршгаас салах тухай цогц асуудлууд байв.

Ийнхүү М.С.Горбачёв ЗХУ-ын эдийн засгийг хурдасгах шаардлагыг ЗХУКН-ын Төв Хорооны 1985 оны 4 дүгээр сарын Бүгд хурал дээр авч хэлэлцсэн. Тэрээр улс орны эдийн засгийг хурдасгахын тулд үндсэн хоёр төлөвлөгөө дэвшүүлж, нэгдүгээрт; эдийн засгийг бий талаар эрчимжүүлэх, улс ардын аж ахуйн удирдлагад ардчилсан төвлөн удирдах ёсыг сэргээн хөгжүүлэх, удирдлагын эдийн засгийн аргыг газар сайгүй нэвтрүүлэх, захирч тушаахаас татгалзах, шинэ санаачилгыг бий талаар дэмжих, хоёрдугаарт; “шинжлэх ухаан-техникийн хувьсгалын ололтыг төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай холбох явдал” гэсэн нэр томъёогоор бусад хөгжингүй орнуудтай хөгжлийн хувьд зэрэгцэх гэсэн зорилтуудыг дэвшүүлснээр түүний “Перестройка” хэмээх бодлого амьдрал дээр хэрэгжиж эхэлсэн юм. “Перестройка”

бол хувьсгал, тэгэхдээ хамгийн энх тайванч, хамгийн ардчилсан хувьсгал мөн хэмээн Өрнөдийн судлаачид бичиж “М.С.Горбачёв буу дуугарахгүй хувьсгал хийж эхэллээ” [10.2 нийр] гэж дэлхий нийтээр цацаж байлаа.

М.С.Горбачёв еөрчлөлт, шинэчлэлтийн үйл явцыг санаачилсны дараа “хар үүл” сарниж эхэлснийг ЗХУ-д “Реформ” гэх болж дараа нь “Перестройка” гэж нэрлэх болжээ. ЗХУКН-ын 4 дүгээр сарын Бүгд хурлаас эхлэн М.С.Горбачёвын эринг “Гласность”, “Перестройка” гэсэн хоёр түлхүүр үгээр илэрхийлэх болсон. Харин Горбачёвын “Перестройка” нь анхнаасаа улс төрийн шинэтгэл хийх зорилгыг агуулаагүй байсан бөгөөд хйн ардад баталгаат амьдралыг олгож, нийгмийн итгэлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн юм. Энэ утгаараа ч эдийн засгийн шинэчлэлтүүдийг хэрэгжүүлж, улмаар нийгэмд ил тод байдлыг бий болгосноор ард түмэндээ “илүү социализм”, “илүү ардчилал”-ыг олгохыг зорьсон. Гэвч шинэтгэлийг хэрэгжүүлэх үүргийг ЗХУКН хүлээх ёстой байлаа. М.С.Горбачёвын хувьд ил тод байдал гэдэг нь социализм болон тийний ололтыг хөндөхгүйгээр оршин байгаа дутагдлыг үнэн мөнөөр шүүмжлэх явдал байсан юм. 1988 оны 7 дугаар сарын эхээр болсон ЗХУКН-ын XIX бага хурал дээр “Ил тод байдал улс нийгмийн эрх ашиг, хийн эрх чөлөөнд хохирол учруулах ёсгүй” [2.493] гэж тэмдэглэсэн ч ил тод байдлыг намын удирдлага дунд, нам доторх үйл ажиллагааг шүүмжлэхэд чиглүүлсэн нь төдийлэн үр дүнгээ өгөлгүй явсаар коммунистууд намынхаа удирдан чиглүүлэх үүргийг няцаах зориг дутсан нь хожмын алдаа болсон хэмээн үздэг.

Нөгөө талаас “Перестройка” бол улс орны социалист нийгмийн хөгжлийн гүнд болж байгаа үйл явцаас урган гарсан өөрчлөлт, шинэчлэлтийн үйл явц байсан. Нэг үгээр хэлбэл, ЗХУ нийгэм-улс төрийн өөрчлөлт хийхэд бэлэн болж, өөрчлөлтийг өөрөө шаардаж гаргаж ирсэн гэж [4.13] хэлж болно. Энэ тухай М.С.Горбачёв “Перестройка”-г ойлгох нь өнөө үед энэ нь чухал болсон шалтгаан” хэмээх номондоо “Улс оронд “Перестройка” явагдах нөхцөл нь бүрэлдчихсэн байсан юм” [5.14] хэмээн дурдсан байна. М.С.Горбачёв “Перестройка” хэмээх бодлогоо социализмын зий тогтолын хүрээнд төсөөлөн сэтгэж, хөгжүүлэхийг эрмэлзэж, социализмыг боловсронгуй болгохыг зорьж байсан. Энэ тухайгаа Михаил Горбачёв “Еөрчлөн байгуулалт шинэ сэтгэлгээ: Манай орон болон дэлхий дахинд” хэмээх зохиолдоо “Бид бийхэн “Перестройка”-г социалист замынхаа дагуу хийж, амьдралаас урган гарсан асуултын хариуг гаднаас биш, харин социализмын хүрээнд эрж олно” [4.37-38] гэсэн байдаг.

М.С.Горбачёв “Перестройка”-г хэрэгжүүлэхдээ гадаад орчны асуудлыг бас хөндөж тавьсан юм. Еереер хэлбэл, ЗХУ-ын дотоод хямралын асуудлуудтай нэгэн зэрэг гадаад бодлогын изел баримтлалыг өөрчлөх, гадна талдаа тааламжтай олон улсын нөхцөл байдлыг бүрдүүлэх шаардлагатайг ойлгожээ. “Перестройка”-г урагш чиглүүлэхдээ дотоод болон гадаад асуудлуудыг нэгэн зэрэг шийдвэрлэх хэрэгтэй хэмээн үзсэнээр “хүйтэн дайн”-ы сөргөлдөөнийг даван туулах үүднээс АНУ-тай яриа хэлэлцээрийн ширээнд сууж, зэвсэглэл хураах асуудлаар хэлэлцээр (М.С.Горбачёв Р.Рейган хоёрын 1985, 1986, 1987 ондууд дахь дээд хэмжээний уулзалтууд) хийх замаар Дорнод Өрнөдийн хоорондын хурцадмал байдлыг намжаах, Афганистанаас эхлээд бүс нутгийн мөргөлдөөнийг зохицуулах (улмаар Зөвлөлтийн цэрэг Афганистанаас 1989 оны эхээр гарсан явдал) дэлхий дахины байдлыг харгалзан үзэж улс бүхэнтэй эдийн засгийн харилцаагаа өргөтгөх эхлэлийг тавьсан нь гадаад бодлогын хүрээнд гарсан эхний томоохон амжилтууд болжээ.

Гэсэн хэдий ч 1980-аад оны дунд үед ЗХУ нь дэлхийн олонх улсуудтай хурц хэвээр харьцаж ирсэн бөгөөд Хятадтай тасарсан харилцаа, (1989 оны 5 дугаар сард Михаил Горбачёв Бээжин хотод айлчилж энэ хоёр орны харилцаа хэвийн байдалдаа эргэн орсон) Ази, Африкийн олон орнуудыг зэвсэглэх уралдаанд АНУ-тай өрсөлдөж

ирсэн нь зүй ёсоор эдийн засгийн амьдралд ул мөрөө үлдээж хямралт, зогсонги байдалд хүргэсэн нэгэн шалтгаан байсаар байв.

Гадаад бодлогын чиг хандлагыг өөрчлөх нэгэн чухал хэсэг нь социалист орнуудтай харилцах асуудлыг шинээр боловсруулах явдал байлаа. Энэ нь нэг үгээр ах дүү орнуудын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох явдлыг таслан зогсоох шийдвэр болж, Москвагаас ямар нэгэн заавар, зөвлөгөө өгөгдөхөө больсноор сталинизмын өвөөс хаа сайгүй салах явдал чухалд тооцогдох болжээ. Иймд ах дүү социалист орнуудад эхэлсэн өөрчлөлтүүд, ард түмний хисэл эрмэлзлийг хүндэтгэн авч “Прагийн хавар” дахин давтагдах аюулыг зайлуулж чадсан.

Ийнхүү “Перестройка”-гийн жилд дэх ЗХУ-ын гадаад бодлогын шинэ зарчим, шинэ чиг хандлага Германы нэгдлийг хангахад голлох үүргийг гүйцэтгэж, ЗХУ Европын болон бусад орнуудад явагдсан хувьсгалт өөрчлөлтүүдийг хүлээн зөвшөөрч, тэдгээр орны ард түмэнд улс орныхоо удирдлагыг, нийгмийн хөгжлийн загвараа хэрхэн сонгох сонголтыг олгож чадсан юм. Хэдийгээр өнөөдөр М.С.Горбачёвыг “Зүүн Европыг өгсөн”, “БНАГУ-ыг зарсан”, “ЗХУ-ыг задалсан” хэмээн буруутгах хүмүүс байгаа ч тэрээр өөрийн гаргасан шийдвэрт үнэнч хэвээр үлдэж, бусад ард түмний хөгжлийн сонголтыг дээдлэн хүндэтгэснээрээ анх удаа ЗХУ өөрийнхөө түүхэнд хаант оросын эзлэн түрэмгийлэх шинж чанартай бодлогоосоо татгалзаж чадсан хэмээн дүгнэх боломжтой юм.

2. “Перестройка”-гийн үзэл санааг Монгол хүлээн авсан тухайд:

1980-аад оны сүүлч 1990-ээд оны эхээр дэлхий улс төрийн байдалд өөрчлөлт гарч социалист систем ахар богино хугацаанд задарсан билээ. Өөрөөр хэлбэл, нийгмийн амьдралын бүхий л салбарыг хамарсан “Перестройка”-г ЗХУ өөрөө эхлэн тавьсан явдал бусад социалист орнуудад хүсэн хүлээж байсан таатай гадаад нөхцөлийг бүрэлдүүлж социалист систем нид ирмэхийн зуурт задран унасан. ЗХУ-д өрнөсөн “Перестройка”-г дэлхийн бусад орнуудын нэгэн адил мөн Монголд ч анхаарал хандуулан ажигласаар байсан бөгөөд түүнийг эзэл санаа социалист орнуудад бэхэлдээ нөлөөлж, 1987-1989 оны заагт Монголын нийгэм, улс төрийн амьдралд өөрчлөлт, шинэчлэлийн урин уур амьсгалыг авч ирсэн [11.7].

“Перестройка” зайлшгүй хэрэгтэй байсан харин хэрэгжүүлэх явцад олон алдаа гаргаснаас хүссэндээ хүрээгүй. 1980-аад он гэхэд ЗХУ-ын нийгмийн тогтолцоо нь нийгэм, эдийн засаг, соёлын хөгжлийг зогсонги байдалд оруулж, нийгмийн бүх салбарын хямрал бодитой аюул болсон яг энэ үед ЗХУ-д “Перестройка” эхэлснээр Дорнод Европын орнууд улмаар социалист Монгол ч энэ хүрээнд гадаад орчноос их хамааралтайгаар татагдан оржээ.

1980-аад он гэхэд манай орон зөвхөн эдийн засгийн бус нийгмийн хүрээнд ч гүнзгий хямралд орсон бөгөөд дэлхийн хөгжлийн нийтлэг хандлагаас улам бүр холдож, Монгол орныг удирдаж байсан МАХН, төр, засгийн хүрээнд хямрал бодитойгоор нүүрлэж ирснээр ардчилсан хувьсгал гарах дотоод нөхцөл бүрэлдсэн.

Монгол оронд бий болсон энэхүү нөхцөл байдлын үед ЗХУ болон бусад социалист оронд болж буй үйл явцыг монголын сэхээтнүүд, залуучууд, шинийг эрэлхийлэн сэтгэгчид, нэгэнт хэвшмэл амьдралаас залхсан ард тэмэн уншиж, сонсож, улмаар “Перестройка”-г угтан хүлээж авч, МАХН-ын Төв Хорооны 1988 оны V Бүгд хурал улс орны эдийн засгийг түргэтгэн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, ардчилал, ил тод байдлыг хөгжүүлэх, гадаад бодлогодоо аль ч улс оронтой адил тэгш харилцах, социализмыг шинэтгэн сайжруулах үндсэн дээр хөгжүүлэх зэрэг өөрчлөлт, шинэчлэлтийн асуудлыг ийнхүү анх хэлэлцэх болсон юм. Нийгмийн улс төрийн системийг бүхэлд нь хамарсан шинэчлэл хийхдээ юуны өмнө нийгмийн улс төрийн манлай хүч болсон намын зохион байгуулалт, үзэл суртлын ажлыг намын улам өсөж байгаа удирдан чиглүүлэх үүрэгт нь нийцүүлэн баяжуулахаас эхлэх нь зүйтэй гэж

үзэж байв. Гэхдээ энэ нь мөн л ЗХУ-ын жишгээр явагдаж, өөрчлөлт, шинэчлэлтийн намын удирдан чиглүүлэх үүрэгтэй шууд холбож үзэж байснаас харагддаг. Өөрөөр хэлбэл, нам өөрийгөө шинэчлэх, улмаар улс төр, эдийн засгийн систем, оюун санааны хүрээнд хийгдэх шинэчлэл нь түүний тулгуур болох өргөн ардчилалд тулгуурлах хэрэгтэй гэсэн. Үүний дараахан монголын залуучуудын дунд нэгдэх, эвсэл байгуулах хөдөлгөөн эхэлсэн бөгөөд МХЗЭ-ийн санаачилгаар “Перестройка”-г үргэлжлүүлэн түргэтгэх зорилготойгоор залуу уран бүтээлчдийн улсын II зөвлөлгөөн болсон нь чухамдаа Монголын ардчилсан холбоо үүсэн бий болох нөхцөлийг бүрэлдүүлсэн юм.

Энэ үед ЗХУ ах дүү орнуудад байрлуулсан зэвсэгт хүчнээ татаж эхэлсний дагуу ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга М.С.Горбачёваас 1988 оны 11 дүгээр сарын 28-нд ирүүлсэн захидалдаа “Зөвлөлтийн цэргийн ихэнх хэсгийг БНМАУ-аас гаргах санал” болгосныг МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо зөвшөөрч хариуг 1988 оны 12 дугаар сарын 1-нд Зөвлөлтийн талд өгснөөр [11.33] олон жилийн турш ЗХУ-ын дагуул орон болж ирсэн Монгол бие даан хөгжих ийд хаалгаа нээх боломжийг олсон.

Ийнхүү 1989 оны 12 дугаар сарын 10-д Монголын Ардчилсан Холбоо мэндэлж, нийгэм улс төрийн шинэчлэлтийг хэрэгжүүлэх тэмцэлд аажмаар шилжиж, “Үнэн”, “Туяа”, “Улаан од”, “Шинэ толь” зэрэг сонинууд ардчиллын үзэл санааг нийгэмд хүргэх гол үүргийг гүйцэтгэх болсноор шүүмжлэлт нийтлэлүүд өдрөөс өдөрт чөлөөтэй нийтлэгдэж, сайд нарын тусгай хангамжийн тухай, МАХН-ын хэмжээг эрх, хэвлэлийн эрх чөлөө, тусгаар тогтнолын хувь заяа, эдийн засгийн гүн гүнзгий хямралын тухай олон асуудлыг хөндөж эхэлснээр Монголын нийгэмд ил тод байдлыг тогтоох тэмцлийн анхны алхам тавигдсан юм.

Монголын Ардчилсан Холбооны араас “Шинэ Дэвшилт Холбоо”, “Ардчилсан Социалист Хөдөлгөөн”, “Монголын Оюутны Холбоо” зэрэг мэндэлж МАХН-ын онц Их хурлыг 1990 оны 3 дугаар сард зарлан хуралдуулж, МАХН-ын Төв Хорооны бүрэлдэхүүнийг өөрчлөх, намын үйл ажиллагааг засаг төрөөс тусгаарлах, улс төрийн бүх хүчнүүдийг тэгш эрхтэйгээр оролцуулан Ардын Түр хурлыг мөн 3 дугаар сард багтаан байгуулах зэрэг шаардлагуудыг төр засгийн өндөрлөгт тавьж, хүсэж хүлээсэн үр дүнд хүрээгүйн улмаас тэмцлийн хурц хэлбэрийг сонгон өлсгөлөн зарлах замаар МАХН-ын Улс Төрийн Товчоог бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох шаардлагыг тулгаснаар Ж.Батмөнхийн мэдэгдлийн хариуд 3 дугаар сарын 9-ний орой 22 цагт “Улс төрийн өлсгөлөн зогсоосон тухай” хариу мэдэгдлийг Ц.Элбэгдорж Сүхбаатарын талбайгаас зарласнаар Монгол Улс коммунист нийгмийн тогтолцоог солих үйл явцыг цус урсгалгүй тайван замаар хэрэгжүүлж чадсан юм.

Дүгнэлт

1980-аад оны эцэс гэхэд дэлхийн социалист систем хөгжлийн хувьд мухардалд орж “Перестройка”-г хийх нөхцөл бүрдсэн. Улмаар мөн оны II хагаст социалист орнуудад хямралт байдлын шинж улам бйр ил болж, социалист систем бйхэлдээ задрах эхний шинж тэмдгүүд мэдрэгдэж эхэлсэн юм. Ийнхүү социалист систем унасан явдал уг системд хамрагдаж байсан орон бүрт томоохон цохилт болж нэг хэсэгтээ л улс төрийн сааталд орсон гэж болно.

М.С.Горбачёв 2006 оны 3 дугаар сард “Новые известия” сонинд өгсөн ярилцлагадаа “Сийлийн иед өөрчлөн байгуулалтын үнэ цэнийг манай ард түмэн ойлгож эхэлж байгаа. Хамгийн гол нь улс орондоо өөрчлөн байгуулалтыг эхлүүлсэндээ би огтхон ч харамсдаггүй” [9.3 нүүр] хэмээн онцлон дурдсан байдаг.

“Перестройка” нь ЗХУ-ын зогсонги байдлыг шийдвэртэй гэтлэн давж, саатуулагч механизмыг эвдэн нийгэм эдийн засгийн хөгжлийг хурдасгах найдвартай,

үр өгөөжтэй механизмыг үүсгэж, нийгмийг ихээхэн эрч хөдлөлтэй болгож, хйн төрөлхтний хөгжлийн цорын ганц гарц болох ардчиллын үүд хаалгыг нээн өгөхөд чиглэгдсэн юм. “Перестройка”-гийн хувь заяаг нийгмийн хөгжлийн хоёр зангилаа асуудал тодорхойлж байсны нэг нь эдийн засгийн шинэтгэл хийх, нөгөө нь нийгмийн бүхий л амьдралыг ардчиллах явдал байв. Ардчилах нь хамгийн гол зүйл мөн. Энэ бол “Перестройка”-гийн зорилгод хүрэх шийдвэрлэгч хэрэгсэл байсан бөгөөд гагцхүү ардчилах замаар л хүний хүчин зүйлийг, нийгмийн амьдралын бүх талыг гүнзгий өөрчилж чадна хэмээн үзэж байсан. Нийгмийг ардчилахаас гадна нам доторх ардчиллыг хэрэгжүүлэх үүднээс “ил тод байдал”, “олон ургальч їзэл санаа” хэмээх ойлголтуудыг гаргаж, олон улсын тавцанд ч нээлттэй ярих, харилцан итгэлцэх зарчимд тулгуурлан “хүйтэн дайн”-ы зөрчлийг “зэвсэг хорогдуулах” бодлогоор эхлүүлж, Германы нэгдлийг хангах асуудлыг сөхөн, Афганистанаас цэргээ татах шийдвэрт гаргаж, ах дүү орнуудаас зэвсэгт хүчээ татаж, тэдгээрийн дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох байр суурийг баримтлах болсон нь олон жилийн турш ЗХУ-ын нөлөөнд байсан улс орнуудад хөгжлийн замаа хайж олох, ард түмнийхээ дуу хоолой, хїсэл эрмэлзэлд нийцсэн төр, засгийг сонгох боломжийг олгосон явдал болсон юм.

Ийнхүү хэтдээ коммунист тогтолцоог түлхэн унгахад чиглэсэн “Перестройка”-г түүний гал голомтоос эхлүүлсэн явдал нь бусад орнуудад тэр дундаа Монголд хүчтэй нөлөөлж, хөгжлийн шинэ эрин үеийг нээж өгсөн юм. М.С.Горбачёвын гадаад бодлогын хэрэгжилт нь тїний нэр хүндийг олон улсын хэмжээнд өсгөж, тэрээр ЗХУ-ын шинэ нүүр царайг төлөөлсөн хүн болж чадсан юм.

Монгол Улсад “Перестройка”-гийн тухай 1987 оноос эхлэн идэвхтэй яригдаж, ЗХУ-аас эхлүүлсэн “Перестройка” монголын ард олонд улс орныхоо өнөөгийн байдал, хэтийн төлөвийг улам тодорхой ойлгож мэдэхэд бодит тус дөхөм болжээ. 1990 оны Монголын ардчилсан хувьсгал нь социалист системийн задралын шууд үр нөлөө, дагавар нь байсан бөгөөд энэ их хувьсгалт өөрчлөлтийг Монголын ард түмний дийлэнх хэсэг нь дэмжээ. Тухайлбал, 2002 онд гаргасан социологийн судалгаанд “хүн амын 90 орчим хувь нь 1990 оны ардчилсан хувьсгалыг зөв зүйтэй зүйл байсан гэж үзэж байна” гээд “Монгол нь дэлхийн коммунист системийн задралын дараа их шилжилт хийж буй 40 гаруй улсын нэгэнд тооцогдож, ...нийгмийн хувьд тоталитар дэглэмээс ардчилсан тогтолцоо руу, эдийн засгийн хувьд төвлөрсөн захиргаадлын аж ахуйгаас зах зээлийн чөлөөт эдийн засгийн тогтолцоо руу давхар шилжилт хийж байгаа улс юм” [8. 9] гэжээ. Энэхүү хувьсгал нь хөдөлгөх хүч, шийдсэн асуудал, байгуулсан нийгэм, эдийн засгийн їр дагавраараа Монголын түүхэнд том үйл явдал болсон юм.

Ном зүй

1. Бжезински.З. ИХ СҮЙРЭЛ ба ХХ зуунд коммунизм мэндэлж мөхсөн нь. УБ. 1995
2. Верт.Н. История Советского Государства. 1900-1991гг. М. 2001
3. Горбачёв. М.С. Илтгэл, өгүүлэл, хэлсэн їг. УБ. 1986
4. Горбачёв. М.С. Ёрчлен байгуулалт шинэ сэтгэлгээ: Манай орон болон дэлхий дахинд. УБ. 1988
5. Горбачёв. М.С. Понять перестройку... Почему это важно сейчас. М. 2006
6. Заанхүү.Ж. 1990 оны ардчилсан хөдөлгөөний түүхэнд холбогдох баримт бичгүүд. Тэргүүн дэвтэр. УБ. 2004
7. ЗХУКН-ын ХХҮІІ Их хурал. Социализмыг боловсронгуй болгох асуудал. УБ. 1986
8. Монголын ардчиллын хөгжил, төлөв хандлага, зорилт. УБ., 2003
9. “Өдрийн сонин” 2006. 03. 03. № 05 /2188/
10. “Үнэн” сонин. 1988. 02. 25. № 48 /16951/ Хүрэлжанцан.Ж. Ардчиллын халуун өдрүүд. УБ. 2004